



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
БАЯН- ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нийцлийн аудитын тайлан

**Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн улсын төсвөөс
санхүүжүүлэх зардлын гүйцэтгэл**

**Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн зардлын
батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан байна.**

Баян-Өлгий аймаг, Өлгий сум

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:

**Баян-Өлгий аймаг дахь
Төрийн аудитын
газар**

Дарга, Тэргүүлэх аудитор
М.Хуанган

Аудитын менежер
Х.Женисбек

Аудитын баг
Аудитор
Д.Назгүл

2017 оны 8 дугаар сар

Аудитын тайлан, дүгнэлттэй
холбоотой асуудлаар нэмж
тодруулах, асууж лавлах зүйл
байвал 99427301 дугаарын утсаар
хандана уу.

ХАЯГ: Аймгийн ЗДТГазрын
байр, 1 дүгээр давхар 110,
112 тоот өрөө

Товчилсон үгийн тайлбар3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй4

**Бүлэг 1 Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны
сонгуулийн батлагдсан төсвийг холбогдох хууль,
журмын дагуу төлөвлөж, хуваарилж, зарцуулсан
эсэх талаар.**

1.1 Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн зардлын
төсвийг зохих журмын дагуу төлөвлөсөн байна.....5-7

1.2 Сонгуулийн зардлын төсвийг сумуудын сонгуулийн
хороодод холбогдох журмын дагуу хуваарилсан байна.....8-9

1.2 Сонгуулийн зардлын батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуул
сана байна.....9-12

**Бүлэг 2 Сонгууль зохион байгуулах зардалд
холбогдох хууль, журамд нийцүүлэн хяналт тавьж
ажилласан эсэх талаар.**

2.1 Сонгуулийн зардлын бүртгэл хөтлөлт,
гүйцэтгэлийн тайланг журмын дагуу
тайлагнаж ирүүлсэн байна..... 13-14

2.2 Хөрөнгийн зарцуулалтанд тавих хяналтыг
журмын дагуу гүйцэтгэсэн байна.....14

Товчилсон үгийн тайлбар

[illegible]

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудитын зорилт:

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2017 оны 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газраас 2017 онд нийлүүлэх аудитын болон ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийнэ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтыг шалгаж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ.

Хамрах хүрээ:

Аудитад Баян-Өлгий аймгийн аймаг, сумын сонгуулийн тойргийн хороодын Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлтэй холбоотой санхүүгийн баримт, тайлан, бусад тайлангуудыг хамруулна.

Эрсдэлийн үнэлгээ:

Аудитын төлөвлөлтийн явцад судалсан баримт материал, хамрах хүрээ, нөхцөл байдалд хийсэн урьдчилсан дүн шинжилгээнд үндэслэн ерөнхий эрсдэлийг “дунд” гэж үнэлсэн.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 100, АДБОУС 400, АДБОУС 4100, Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журмыг баримтлан шалгадагч байгууллагаас авсан мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгах, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, харьцуулах, дүн шинжилгээ хийх, түүвэрлэлт хийх болон аудитын бусад горим, арга зүйг ашиглаж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулна.

Аудитын багийн бүрэлдэхүүн:

Аудитыг Аудитын газрын аудитор Д.Назгүл 2016 оны 07 дугаар сарын 24-нөөс эхлэн 08 дугаар сарын 07-ны хооронд хийж гүйцэтгэв.

Бүлэг 1

Сонгуулийн зардлын батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Оршил

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулиар Баян-Өлгий аймгийн 1, сумын 13 сонгуулийн хороо, 89 хэсгийн хороодод нийт 336.6 сая төгрөгийн төсөв баталж, санхүүжилт хуваарилсан байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн сонгуулийн хоёр дахь санал хураалтад тус аймагт нийт 127.0 сая төгрөгийн санхүүжилт хуваарилагдсан байна.

Аймгийн Сонгуулийн хороо зарим сумд сонгуулийн зардлын гүйцэтгэлийн тайлангаа хугацаандаа ирүүлээгүйтэй холбоотой хугацаа хожимдуулж, аймгийн сонгуулийн зардлын тайланг 8 дугаар сарын 03-ны өдрийн 42 тоот албан тоотоор ирүүлсэн.

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны сонгуулийн батлагдсан төсвийг холбогдох хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилж, зарцуулсан эсэх талаар

Сонгуулийн зардлын батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

1.1. Батлагдсан төсвийг зохих эдийн засгийн ангиллын дагуу нутаг дэвсгэрийн хэмжээ, сонгогчийн тоо болон сум, дүүргийн сонгуулийн хороо, санал авах байр, тэдгээрт ажиллах гишүүдийн тоог харгалзан төлөвлөсөн эсэх талаар.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн зардлын төсвийг зохих журмын дагуу төлөвлөсөн байна.

Сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2-д “Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо нь сонгуулийн төв байгууллагын шууд удирдлагын дагуу Улсын Их Хурал, түүний гишүүний болон Ерөнхийлөгчийн сонгуулийг өөрийн нутаг дэвсгэрт зохион байгуулна”, 31.4-д “Сонгуулийн төв байгууллага аймаг, нийслэлийн сонгуулийн хороог дарга, нарийн бичгийн дарга, гишүүд, нийт таваас есөн хүний бүрэлдэхүүнтэйгээр, санал авах өдрөөс 70-аас доошгүй хоногийн өмнө байгуулна” гэсний дагуу Сонгуулийн Ерөнхий Хорооны 2017 оны

04 дүгээр сарын 12-ны өдрийн 10 тоот тогтоолоор Баян-Өлгий аймгийн Сонгуулийн хороог 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

Уг тогтоолоор Сонгуулийн тухай хуулийн 33.4-д “Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо сум, дүүргийн сонгуулийн хороог дарга, нарийн бичгийн дарга, гишүүд, нийт таваас есөн хүний бүрэлдэхүүнтэйгээр санал авах өдрөөс 65-аас доошгүй хоногийн өмнө байгуулна” гэж заасны дагуу сумуудын сонгуулийн хороодыг байгуулж, ажиллуулахыг аймгийн сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга нарт даалгасан байна.

Аймгийн Сонгуулийн хорооны 2017 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 01 тоот тогтоолоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах сумуудын Сонгуулийн хороодыг тус бүр 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулжээ. Аймгийн Сонгуулийн хорооны 2017 оны 5 дугаар сарын 08-ны өдрийн хуралдааны шийдвэрээр Ногооннуур, Буянт, Улаанхус сумуудын сонгуулийн хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулсан байна.

Сонгуулийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д “Сонгогчдын санал авах, тоолох зорилгоор сум, дүүргийн хурлын Тэргүүлэгчид улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг харгалзан тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн оршин суугчдын байнга оршин суугаа газрын бүртгэлийн мэдээллийн санг үндэслэн сонгуулийн хэсгийг ээлжит сонгуулийн санал авах өдрөөс 120-иос доошгүй хоногийн өмнө байгуулж, хэсгийн нутаг дэвсгэр, төвийг зарлана” гэж заасны дагуу 23.2-д “Нэг хэсэг нь суманд 2000-аас дээшгүй, аймгийн төвд 2500-аас дээшгүй сонгогчтой байна” гэснийг баримтлан хүн амын тоо , ачааллыг харгалзан нэг суманд 4-13 хүртэл хэсэгтэй буюу 13 суманд 89 хэсгийн хороо ажиллуулахаар зохион байгуулжээ.

Эдгээр 89 хэсгийн хороонд хэсгийн сонгуулийн хорооны тус бүр нэг ахлах зохион байгуулагч, 503 зохион байгуулагч буюу бүгд 594 хүн ажиллахаар зохион байгуулсан байна. Аймгийн Сонгуулийн хорооны бүрэлдэхүүнд 9, мэдээллийн технологийн багт 5, санхүү, хангамж үйлчилгээний хэсэгт 2 бүгд 16 хүний бүрэлдэхүүнтэй ажиллажээ.

Сонгуулийн Ерөнхий хорооны 2016 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор баталсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай” журмын 2.2-т СЕХороо нь аймгийн сонгуулийн хороонд дараах зардлыг хуваарилна”, 2.3-т “Аймгийн сонгуулийн хороо нь СЕХорооноос өгсөн зөвлөмж, аргачлалын дагуу сумын сонгуулийн салбар комисст дараах зардлыг хуваарилна” гэсний дагуу холбогдох зардлуудыг төлөвлөжээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн Баян-Өлгий аймаг дахь сонгуулийн хорооны төсөв:

/мянган төгрөг/

№	Зардлын нэр	Төсөв
1	Сургалтын зардал	15494,6
2	Тогтоол, протокол, бусад маягт хэвлүүлэх зардал	250,0
3	Бичиг хэргийн зардал	19420,0
4	Шуудан холбооны зардал	18770,0
5	Унааны зардал	33900,0
6	Сурталчилгааны зардал	8000,0
7	Сурталчилгааны материал хүргэх зардал	1625,0
8	Санал авах байр бэлтгэх зардал	17800,0
9	Саналын хуудас устгах зардал	1000,0
10	Саналын хуудас хүргэх	3296,0
11	Санал тоолох төхөөрөмж хүргэх, буцаан татах зардал	17555,0
12	Мэдээ дамжуулах зардал	5475,0
13	Томилолтын зардал	5108,9
14	Эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх зардал	3738,0
15	Болзошгүй зардал	3000,0
16	Сонгуулын байгууллагын ажилтаны урамшуулал, хоолны зардал	154011,6
17	Мэдээллийн технологийн багийн гишүүн, даамлын сонгуулийн хороонд ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал	28200,8
	НИИТ ДҮН	336644,9

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 2 дахь санал хураалтын Баян-Өлгий аймаг дахь сонгуулийн хорооны төсөв:

/мянган төгрөг/

№	Зардлын нэр	Төсөв
1	Бичиг хэргийн зардал	1695,0
2	Шуудан холбооны зардал	2140,0
3	Унааны зардал	11700,0
4	Саналын хуудас хүргэх	3296,0
5	Санал тоолох төхөөрөмж хүргэх, буцаан татах зардал	8277,0
6	Мэдээ дамжуулах зардал	5475,0
7	Эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх зардал	3738,0
8	Мэдээллийн технологийн багийн гишүүн, даамлын сонгуулийн хороонд ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал	14200,0
9	Санал авах байр бэлтгэх зардал	5300,0
10	Сонгуулын байгууллагын ажилтаны урамшуулал, хоолны зардал	71200,0
	НИИТ ДҮН	127021,0

Аймгийн Сонгуулийн хороо нь Сонгуулийн тухай хуулийн 32 дугаар зүйлд заасан “Аймаг, нийслэлийн сонгуулийн эрх хэмжээ”-ний хүрээнд: 32.1.1-ийн “сонгууль зохион байгуулах ажлыг төлөвлөх, түүнийг зохион байгуулах арга хэмжээг авах”, 32.1.3-ийн “харьяалах сум, дүүргийн сонгуулийн хорооны үйл ажиллагааг зохион байгуулалт, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах” гэсний дагуу сумуудын сонгуулийн хороодтой тухай бүр харилцаж, арга зүйн удирдлагаар хангаж ажилласан байна.

32.1.6-д “улсын болон орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгийг зориулалтын дагуу захиран зарцуулах, хуваарилах, зарцуулалтад нь хяналт тавих”- гэж заасан эрх үүргээ хэрэгжүүлж, Сонгуулийн Ерөнхий хорооноос өгсөн чиглэл, аргачлалын дагуу сумуудын сонгуулийн хороодод төсвийг тухай бүр

хуваарилж, хэрхэн зарцуулах талаар чиглэл өгч, зарцуулалтын тайлан гаргуулан хянаж хүлээж авсан байна.

1.2.Төсвөөс олгосон хөрөнгийг сумуудын сонгуулийн хороодод холбогдох журмын дагуу хуваарилсан эсэх талаар.

Сонгуулийн зардлын төсвийг сумуудын сонгуулийн хороодод холбогдох журмын дагуу хуваарилсан байна.

Монгол Улсын СЕХороо нь 2017 оны 4-6 дугаар саруудад 113 тоот албан бичгээр тус аймаг дахь сонгуулийн хорооны төсвийн эхний хэсгийн санхүүжилтэнд шилжүүлсэн 29,1 сая төгрөгийн зарцуулалтын тухай тайлбар, төсвийн хуваарийг, 172 тоот албан бичгээр 2 дахь хэсгийн санхүүжилтэнд шилжүүлсэн 86,2 сая төгрөгийн зарцуулалтын талаар тайлбар болон төсвийн хуваарийг, 199 тоот албан бичгээр 3 дахь хэсгийн санхүүжилтэнд шилжүүлсэн 31,7 сая төгрөгийн санхүүжилтийн зарцуулалтын талаар тайлбар болон төсвийн хуваарийг, 210 тоот албан бичгээр 4 дэхь хэсгийн санхүүжилтэнд шилжүүлсэн 182,1 сая төгрөгийн санхүүжилтийг зарцуулах талаар тайлбар болон төсвийн хуваарийг тус тус ирүүлсэн байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны сонгуулийн 2 дахь санал хураалтыг зохион байгуулах зардлын санхүүжилтэнд шилжүүлсэн 127,0 сая төгрөгийн санхүүжилтийг зарцуулах талаар тайлбар болон төсвийн хуваарийг 260, 295 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулиар Баян-Өлгий аймгийн сонгуулийн хороонд 336.6 сая төгрөгийн, хоёр дахь санал хураалтад 127,0 сая төгрөгийн, нийтдээ 463,6 сая төгрөгийн санхүүжилт хуваарилагдсан байна. Үүнээс сумын сонгуулийн хэсгийн хороодод ээлжит сонгуулийн зардалд 248,4 сая төгрөгийн, 2 дахь санал хураалтад 100,8 сая төгрөгийн, бүгд 349,2 сая төгрөгийн санхүүжилтийг хуваарилсан байна.

Сумуудын сонгуулийн хороодод төсөв хуваарилахдаа “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай” журмын 2.3.1-2.3.10- дахь заалтуудыг мөрдөж, аймгийн сонгуулийн хорооны даргын тушаалаар сонгуулийн зардлын төсвийг зардал тус бүрээр сумдын сонгуулийн хороодод хуваарилан санхүүжилтийг олгосон байна.

№	Сумуудын нэр	Санал авах хэсгийн тоо	Сонгуулийн хорооны гишүүний тоо	Сонгуулийн хорооны ахлах зохион байгуулагч	Зохион байгуулагчийн тоо	Олгосон төсөв	Эзлэх хувь
1	Алтай сум	5	7	1	27	20678,2	5,9
2	Алтанцөгц	4	7	1	20	16459,6	4,7
3	Баяннуур	5	7	1	27	20678,3	5,9
4	Бугат	4	7	1	22	16820,0	4,8
5	Булган	7	7	1	37	27361,9	7,8

6	Буянт	4	7	1	20	15949,2	4,6
7	Дэлүүн	10	7	1	52	36799,9	10,5
8	Ногооннуур	8	7	1	46	30269,4	8,7
9	Сагсай	6	7	1	32	25426,1	7,3
10	Толбо	6	7	1	32	22802,1	6,5
11	Улаанхус	8	7	1	46	32333,0	9,2
12	Цэнгэл	9	7	1	53	36427,2	10,4
13	Өлгий	13	7	1	89	47196,0	13,5
	ДҮН	89	91	13	503	349201,2	100

1.3. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу захиран зарцуулсан эсэх талаар.

Сонгуулийн зардлын батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий хороо нь сонгуулийн хороонд батлагдсан төсвийг хуваарилж, санхүүжүүлэх тухай бүрдээ төсвийн тухай тайлбарыг ирүүлж, хэрхэн хуваарилж, зарцуулах, тайлагнах талаар аймгийн Сонгуулийн хороог арга зүйн удирдамжаар хангаж ажилласан байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн Баян-Өлгий аймаг дахь сонгуулийн хорооноос ирүүлсэн төсвийн гүйцэтгэл:

/мянган төгрөг/

№	Зардлын нэр	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Сургалтын зардал	15494,6	15494,6	
2	Тогтоол, протокол, бусад маягт хэвлүүлэх зардал	250,0	250,0	
3	Бичиг хэргийн зардал	19420,0	19420,0	
4	Шуудан холбооны зардал	18770,0	18770,0	
5	Унааны зардал	33900,0	33900,0	
6	Сурталчилгааны зардал	8000,0	8000,0	
7	Сурталчилгааны материал хүргэх зардал	1625,0	1625,0	
8	Санал авах байр бэлтгэх зардал	17800,0	17800,0	
9	Саналын хуудас устгах зардал	1000,0	1000,0	
10	Саналын хуудас хүргэх	3296,0	3296,0	
11	Санал тоолох төхөөрөмж хүргэх, буцаан татах зардал	17555,0	17555,0	
12	Мэдээ дамжуулах зардал	5475,0	5475,0	
13	Томилолтын зардал	5108,9	5108,9	
14	Эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх зардал	3738,0	3738,0	
15	Болзошгүй зардал	3000,0	3000,0	
16	Сонгуулын байгууллагын ажилтаны урамшуулал, хоолны зардал	154011,6	154011,6	
17	Мэдээллийн технологийн багийн гишүүн, даамлын сонгуулийн хороонд ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал	28200,8	28200,8	
	НИЙТ ДҮН	336644,9	336644,9	

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 2 дахь санал хураалтын Баян-Өлгий аймаг дахь сонгуулийн хорооноос ирүүлсэн төсвийн гүйцэтгэл:

/мянган төгрөг/

№	Зардлын нэр	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Бичиг хэргийн зардал	1695,0	1695,0	
2	Шуудан холбооны зардал	2140,0	2140,0	
3	Унааны зардал	11700,0	11700,0	
4	Саналын хуудас хүргэх	3296,0	3296,0	
5	Санал тоолох төхөөрөмж хүргэх, буцаан татах зардал	8277,0	8277,0	
6	Мэдээ дамжуулах зардал	5475,0	5475,0	
7	Эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх зардал	3738,0	3738,0	
8	Мэдээллийн технологийн багийн гишүүн, даамлын сонгуулийн хороонд ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал	14200,0	14200,0	
9	Санал авах байр бэлтгэх зардал	5300,0	5300,0	
10	Сонгуулын байгууллагын ажилтаны урамшуулал, хоолны зардал	71200,0	71200,0	
	НИЙТ ДҮН	127021,0	127021,0	

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит болон 2 дахь санал хураалтын сонгуулийн зардлын гүйцэтгэлийг шалгасан аудитын дүнгээр Баян-Өлгий аймаг дахь Сонгуулийн хорооны төсвийн гүйцэтгэл дараах байдалтай байна.

/мянган төгрөг/				
№	Зардлын нэр	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Сургалтын зардал	15494,6	16049,3	554,7
2	Тогтоол, протокол, бусад маягт хэвлүүлэх зардал	250,0		-250,0
3	Бичиг хэргийн зардал	19420,0	19420,0	
4	Шуудан холбооны зардал	18770,0	18770,0	
5	Унааны зардал	33900,0	35115,4	1215,4
6	Сурталчилгааны зардал	8000,0	8000,0	
7	Сурталчилгааны материал хүргэх зардал	1625,0	1625,0	
8	Санал авах байр бэлтгэх зардал	17800,0	17800,0	
9	Саналын хуудас устгах зардал	1000,0	1000,0	
10	Саналын хуудас хүргэх	3296,0	3296,0	
11	Санал тоолох төхөөрөмж хүргэх, буцаан татах зардал	17555,0	17555,0	
12	Мэдээ дамжуулах зардал	5475,0	5475,0	
13	Томилолтын зардал	5108,9	5077,8	-31,1
14	Эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх зардал	3738,0	3738,0	
15	Болзошгүй зардал	3000,0	1511,0	-1489,0
16	Сонгуулын байгууллагын ажилтаны урамшуулал, хоолны зардал	154011,6	154011,6	
17	Мэдээллийн технологийн багийн гишүүн, даамлын сонгуулийн хороонд ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал	28200,8	28200,8	
	НИЙТ ДҮН	336644,9	336644,9	

Ээлжит сонгуулийн зардалд батлагдсан төсвийн зүйл ангиас тогтоол протокол, бусад маягт хэвлүүлэх зардлыг 250,0 мянган төгрөгөөр, томилолтын зардлыг 31,1 мянган төгрөгөөр, болзошгүй зардлыг 1489,0 мянган төгрөгөөр буюу бүгд дүнгээр 1770,1 мянган төгрөгөөр хэмнэж, сургалтын зардалд 554,7 мянган төгрөгийг, унааны зардалд 1215,4 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулсан байна.

Ээлжит сонгуулийн төсвийн 54,1 хувийг буюу 182,2 сая төгрөгийг сонгуулийн байгууллагын ажилтнуудын урамшуулал, хоолны мөнгө, 4,7 хувийг буюу 16,0 сая төгрөгийг сургалтын зардал, 5,3 хувийг буюу 17,8 сая төгрөгийг сонгуулийн байр бэлтгэх зардал, 11,3 хувийг буюу 38,2 сая төгрөгийг бичиг хэрэг, шуудан холбооны зардал, 24,6 хувийг буюу 82,4 сая төгрөгийг тээвэр шатахуун, томилолт, сурталчилгаа, эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх, мэдээ дамжуулах, санал тоолох төхөөрөмж хүргэх, буцаан татах зардал болон саналын хуудас хүргэх, устгах болон болзошгүй зардалд зарцуулсан байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 2 дахь санал хураалтын Баян-Өлгий аймаг дахь сонгуулийн хорооны төсвийн гүйцэтгэл:
/мянган төгрөг/

№	Зардлын нэр	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Бичиг хэргийн зардал	1695,0	1695,0	
2	Шуудан холбооны зардал	2140,0	1940,0	-200,0
3	Унааны зардал	11700,0	11700,0	
4	Саналын хуудас хүргэх	3296,0	3296,0	
5	Санал тоолох төхөөрөмж хүргэх, буцаан татах зардал	8277,0	7277,0	-1000,0
6	Мэдээ дамжуулах зардал	5475,0	3475,0	-2000,0
7	Эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх зардал	3738,0	3738,0	
8	Мэдээллийн технологийн багийн гишүүн, даамлын сонгуулийн хороонд ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал	14200,0	14100,0	-100,0
9	Санал авах байр бэлтгэх зардал	5300,0	5300,0	
10	Сонгуулын байгууллагын ажилтаны урамшуулал, хоолны зардал	71200,0	74500,0	3300,0
	НИЙТ ДҮН	127021,0	127021,0	

2 дахь санал хураалтын сонгуулийн зардлын төсвийн зүйл ангиас шуудан холбооны зардлыг 0,2 сая төгрөгөөр, санал тоолох төхөөрөмж хүргэх, буцаан татах зардлыг 1,0 сая төгрөгөөр, мэдээ дамжуулах зардлыг 2,0 сая төгрөгөөр, мэдээллийн технологийн багийн гишүүн, даамлын сонгуулийн хороонд ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардлыг 0,1 сая төгрөгөөр буюу бүгд 3,3 сая төгрөгөөр хэмнэж сонгуулийн байгууллагын ажилтаны урамшуулалд гүйлгэн зарцуулсан байна.

2 дахь санал хураалтанд батлагдсан төсвийн 69,7 хувийг буюу 88,6 сая төгрөгийг сонгуулийн байгууллагын болон мэдээлэл технологийн баг, даамлын сонгуулийн хороонд ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардалд, 9,2 хувийг буюу 11,7 сая төгрөгийг тээвэр шатахуун, унааны зардалд, 2,8 хувийг буюу 3,6 сая төгрөгийг бичиг хэрэг, шуудан холбооны зардалд, 18,3 хувь буюу 23,1 сая төгрөгийг саналын хуудас хүргэх, санал тоолох төхөөрөмж хүргэх, буцаан татах, мэдээ дамжуулах, эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх, санал авах байр бэлтгэх зардалд зарцуулсан байна.

Сонгуулийн Ерөнхий Хорооны 2017 оны 32 дугаар тогтоолоор баталсан сонгуулийн хороонд ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардлын

хэмжээг зөрчиж аймгийн сонгуулийн хорооны гишүүд болон сонгуулийн хороонд ажилласан ажилтнуудад 3300,0 мянган төгрөгийн урамшуулал илүү олгосон зөрчил илэрсэн тул ХХОАТ-т төлсөн 330,0 мянган төгрөгийг суутган тооцож, 2970,0 мянган төгрөгийг нөхөн төлүүлэхээр акт тогтоов.

Бүлэг 2

Сонгууль зохион байгуулах зардалд шат, шатны хяналтыг холбогдох хууль, журамд нийцүүлэн зохих журмын дагуу тавьж ажилласан байна.

2. Сонгууль зохион байгуулах зардалд холбогдох хууль, журамд нийцүүлэн хяналт тавьж ажилласан эсэх талаар

Сонгууль зохион байгуулах зардалд шат, шатны хяналтыг холбогдох хууль, журамд нийцүүлэн зохих журмын дагуу тавьж ажилласан байна.

2.1. Сонгуулийн зардлын бүртгэл хөтлөлт, гүйцэтгэлийн тайланг журмын дагуу тайлагнасан эсэх талаар

Сонгуулийн зардлын бүртгэл хөтлөлт, гүйцэтгэлийн тайланг журмын дагуу тайлагнаж ирүүлсэн байна.

Сумуудын сонгуулийн хороо нь тайлангаа СЕХ-ны 2016 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор баталсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай” журамын 4.4-т заасан хугацаанд буюу сонгуулийн санал хураалт дууссан өдрөөс хойш 3 хоногийн дотор гарган аймгийн сонгуулийн хороонд хүргэх ёстой.

Булган, Өлгий, Алтай, Буянт, Дэлүүн, Толбо, Баяннуур, Сагсай сумууд тайлангаа хугацаандаа ирүүлсэн байна. Бугат, Алтанцөгц, Цэнгэл, Улаанхус, Ногооннуур сумууд 15-27 хоногоор хугацаа хэтрүүлж тайлангаа ирүүлсэн байна.

Сумын сонгуулийн хороод сонгуулийн зардлын дансны орлого, зарлагын гүйлгээний холбогдох анхан шатны баримтуудыг зохих журмын дагуу бүрдүүлж, бүртгэл хөтлөлтийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулинд заасны дагуу хөтөлж, тайлангаа албан бичгээр тайлангийн танилцуулга, тодруулгын хамт ирүүлэх ёстой.

Аймгийн Сонгуулийн хороо, Булган, Ногооннуур, Өлгий, Баяннуур, Алтай, Толбо, Улаанхус, Дэлүүн, Алтанцөгц, Бугат, Цэнгэл сумууд нь санхүүгийн тайлангийн танилцуулга, тодруулгыг бичиж ирүүлээгүй буюу “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай” журмын 4.2.2, 4.3.2-т заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Сумуудаас Сагсай сум нь санхүүгийн тайлангийн танилцуулга, тайлбарыг зохих журмын дагуу бичиж ирүүлсэн байна.

Өлгий, Баяннуур, Буянт, Алтай сумын сонгуулийн хороо нь СЕХ-ны 2016 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн 04 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтад заасны дагуу сонгуулийн зардлын тайлангаа гаргаж ирүүлээгүй байна.

Өлгий сумын сонгуулийн зардлын санхүүгийн анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтгүй буюу сонгуульд ажилласан ажилтнуудын урамшуулал, хоолны мөнгийг банкин дахь дансаар хувь хүний дансанд шилжүүлэхдээ банкны теллерийн гарын үсэг зуруулж баталгаажуулаагүй байна.

Аймгийн Сонгуулийн хороо нь сумуудаас ирүүлсэн сонгуулийн зардлын тайланг хянаж, нэгтгээд тайланг журмын дагуу тайлагнасан байна.

2.2.Хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг хууль, журмын дагуу гүйцэтгэсэн эсэх талаар.

Хөрөнгийн зарцуулалтанд тавих хяналтыг журмын дагуу гүйцэтгэсэн байна.

Аймгийн сонгуулийн хорооны зардлын дансны 1 дүгээр гарын үсгийг аймгийн Сонгуулийн хорооны дарга Д.Аманбек, 2 дугаар гарын үсгийг сонгуулийн хорооны нягтлан бодогчоор томилогдсон аймгийн ИТХурлын нягтлан бодогч Х.Съезд нар зурж сонгуулийн зардалд хуваарилагдсан төсвийг захиран зарцуулсан байна.

Сумуудын Сонгуулийн хорооны дарга нар сонгуулийн зардлын дансны 1 дүгээр гарын үсгийг, нарийн бичгийн дарга буюу нягтлан бодогчоор томилогдсон ажилтан 2 дугаар гарын үсгийг зурж, сонгуулийн зардлын төсвийг захиран зарцуулжээ.

Аймаг, сумуудын Сонгуулийн хорооны зардлын дансанд зохих журмын дагуу гарын үсгийн баталгаа бүрдүүлж, хуваарилагдсан төсвийг хөрөнгийн зарцуулсан байна.

Аймгийн Сонгуулийн хороо нь сумуудад сонгуулийн зардлын төсөв хуваарилахдаа, батлагдсан төсвийг баримталж, зохих зардлын зүйл ангиар зарцуулах талаар чиглэл өгч, сонгуулийн төсвийн зарцуулалтанд хяналт тавьж ажилласан байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1.Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны сонгуулийн зардлын батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

2.Аймгийн сонгуулийн хорооны гишүүдэд Сонгуулийн Ерөнхий Хорооноос тогтоосон хэмжээнээс илүү урамшуулал олгосон байна.

3.Сонгууль зохион байгуулах зардалд холбогдох хууль, журамд нийцүүлэн зохих журмын дагуу хяналт тавьж ажилласан байна.

Байгууллагын санал

Аймгийн Сонгуулийн хорооны санал:


**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
СОНГУУЛИЙН ХОРОО**
83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/факс: (976) 7042-2595

2017.08.11. № 43
танай _____ -ны № _____ -т

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны сонгуулийн ээлжит ба хоёр дахь санал хураалтын зардлын тайланд аудит зохих журмын дагуу хийгдсэн байна.

Аудитаар илэрсэн алдаа зөрчлийг хугацаанд нь барагдуулах болно.

ДАРГА  Д. АМАНБЕК

000003

Тайланг хянаж, баталгаажуулсан:

Дарга, тэргүүлэх аудитор

М.Хуанган

Тайланг хянасан:

Аудитын менежер

Х.Женисбек

Тайланг бэлтгэсэн :

Аудитор

Д.Назгүл